ГОВЬСҮМБЭР АЙМАГ

**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 05 өдөр      Дугаар А/79      Баянтал сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэр нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 4.13 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2022 оны Засаг даргын нөөц хөрөнгөөр хийгдсэн "Ерөнхий боловсролын сургуулийг камержуулах" ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч дарга)

Гишүүд:
- Д.Цэрэнням (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)
- Э.Түмэн-Эрдэнэ (1-р багийн Засаг дарга)
- Х.Ариунгуа (ЗДТГ-ын Санхүү албаны ерөнхий нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Ж.Мөнхнаран (Ерөнхий боловсролын сургуулийн Аж ахуйн нярав)

2.Уг ажлыг чанартай зохион байгуулж тайлагнахыг ажлын хэсгийн дарга /Э.Эрхэмбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2021 ajil/zahiramj.doc

42122024З

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 05 өдөр Дугаар А/79 Баянтал сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэр нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 4.13 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2022 оны Засаг даргын нөөц хөрөнгөөр хийгдсэн "Ерөнхий боловсролын сургуулийг камержуулах" ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч дарга)
Гишүүд: Д.Цэрэнням (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)
Э.Түмэн-Эрдэнэ (1-р багийн Засаг дарга)
Х.Ариунгуа (ЗДТГ-ын Санхүү албаны ерөнхий нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Ж.Мөнхнаран (Ерөнхий боловсролын сургуулийн Аж ахуйн нярав)

2.Уг ажлыг чанартай зохион байгуулж тайлагнахыг ажлын хэсгийн дарга /Э.Эрхэмбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2021 ajil/zahiramj.doc

№ 4212202413

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 05 өдөр Дугаар А/81

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа,нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/283 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Баянтал сумын хэмжээнд цэргийн жинхэнэ албанд татах ажлыг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн дотор зохион байгуулсугай.

2.Цэрэг бүртгэлийн ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | В.Гантуяа (Тамгын газрын дарга) |
| Гишүүд: | Н.Түмэн-Эрдэнэ (1 дүгээр багийн Засаг дарга) |
| | Т.Ган-Эрдэнэ (2 дугаар багийн Засаг дарга) |

3.Цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийн ажил үүргийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар, комиссын ажиллах хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Цэргийн бүртгэлийн хугацаанд нь зохион байгуулж, дүнг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга (В.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

0421202

[illegible] АЙМАГ

БАЯНГ[illegible] СУМЫН ЗАСАГ ДАРГЫН

ЗАХИРАМЖ

2022 - 10 - 05 А/82

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны 10 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулагдах аймгийн Засаг даргын нэрэмжит “Боржигин түмний дуулал-2022” урлагийн наадамд Төрийн болон Төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагчдыг идэвхтэй хамруулж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Э.Эрхэмбаатар ( Засаг даргын Орлогч дарга) |
| Гишүүд: | В.Гантуяа ( ЗДТГ-ын дарга ) |
| | Д.Цэрэнням (ЕБС-ийн захирал) |
| | Б.Энхмэнд (Цэцэрлэгийн эрхлэгч) |
| | А.Батжаргал (“Талын илч” ОНӨААТҮГ-н дарга) |
| | Э.Баасангарав ( Эрүүл мэндийн төвийн дарга) |
| Нарийн бичгийн дарга: | Х.Энхжаргал ( Соёлын төвийн дарга) |

2. Аймгийн урлагийн бага наадамд оролцох баг, бүрэлдэхүүнийг идэвхтэй хамруулан, үйл ажиллагааны явц, үр дүнг тайлагнан ажиллахыг ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/83 Баянтал сум

Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг
дахин явуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.2, Монгол улсын засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, сумын Иргэдийн Төлөөлөгчдын хурлын 2021 оны 12 дугаар 01-ний өдрийн хуралдааны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 5 нэгж талбарын байршил, хэмжээ, газрын анхны үнэ зориулалтыг хавсралтаар батлсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг танхимын хэлбэрээр явуулах бөгөөд дуудлага худалдааг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулсугай.

3. Дуудлага худалдаа явуулах зар мэдээг 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж, холбогдох журмын дагуу танхимаар оролцогчдын материалыг хүлээн авч дуудлага худалдаа зохион байгуулахыг сумын Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

421220261

Баянтал сумын Засаг даргын
2022 оны 10 дугаар сарын 17 өдрийн
А/83 дугаар захирамжийн хавсралт

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ, дэнчингийн хэмжээ, газрын хэмжээ, байршил, зориулалт

| дд | Газрын байршил | Баг | Газрын хэмжээ /м2/ | Зориулалт | Дуудлага худалдааны анхны үнэ | Дэнчингийн хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ган зам-1-100 тоот хаягын хойд талд | 2 | 203 | Худалдаа үйлчилгээ | 162400 | 16240 |
| 2 | 621-р замын хойд талд | 1 | 2000 | Худалдаа үйлчилгээ | 1600000 | 160000 |
| 3 | 621-р замын хойд талд | 1 | 2000 | ШТС | 1600000 | 160000 |
| 4 | Нэбу ШТС-ийн хойд талд | 1 | 2000 | Худалдаа үйлчилгээ | 1600000 | 160000 |
| 5 | Үйлдвэрлэлийн бүсийн хойд хэсэгт | 1 | 10000 | Үйлдвэр | 6400000 | 640000 |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/84 Баянтал сум

Захирамж хүчингүй болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дүгээр зүйлийн 66.1, 66.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч иргэн Боржигин овогтой Хүүхэнгийн Мөнхбат нь тус сумын 1 дүгээр баг Цэргийн ангийн урд талд байршилтай фермрын зориулалтай 0.04 га (400м2) газар дээрх обекътын тодорхой хэсэг нь Эрээн шонтын наад дунд бууц хэмээх газартай давхцалтай байгаа тул зөрчлийг арилгах хүртэл сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/122 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2. Газрын зөрчлийг арилгуулж, иргэдийн эзэмшиж буй газарт хяналт тавиж, ажиллахыг сумын Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

4212202257

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/185 Баянтал сум

Газар ашиглах эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, 44 дүгээр зүйлийн 44.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ганхүдрийн хүрд ХХК /5460115/нь Баянтал сумын 1 дүгээр баг, Сансар 4-400 тоот хаягт байрлах 4203002139 нэгж талбарын дугаартай 20000м2 (2га) газрын газар ашиглах эрхийн гэрчилгээг сунгуулах хүсэлт гаргасан тул үйлдвэрлэлийн зориулалтаар 5 жилийн хугацаатайгаар сунган ашиглуулсугай.

2. Хуулийн дагуу газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газраа зүй зохистой ашиглахыг Ганхүдрийн хүрд ХХК-ны захирал /Liu Sheng/-д үүрэг болгосугай.

3. Газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг хуулийн дагуу сунгаж буй Ганхүдрийн хүрд ХХК-тай газар ашиглах гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг сумын Газрын даамал /Ц.Загарсүрэн/-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны А/61 дүгээр захирамжийн 3 дугаар бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

42122024



Сумын Засаг даргын 2022 оны
10 сарын 17-ны өдрийн А/85 дугаар
захирамжийн хавсралт

## Ганхүдрийн хүрд ХХК-ийн хугацааг сунгаж буй газрын байршлын зураг




---000---

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/86 Баянтал сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дугаар зүйлийн 30.1, 52 дугаар зүйлийн 52.7 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус
үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэр бүхий 2 иргэнд өвөлжөө, хаваржааны доорхи газрын зориулалтаар хавсралтад заасан газрын байршилд 15 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрх олгосугай.
2. Дээрх газар эзэмших эрх авсан иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан,гэрчилгээ олгож, газрын төлбөр тооцох, газрын улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

42122024 9

Сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 17 ны өдрийн А/86 дугаар захирамжийн хавсралт

# Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг шинээр эзэмшиж байгаа иргэдийн нэрсийн жагсаалт

| дд | Газар эзэмшигчийн | | | | Эзэмшсэн газрын | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эцэг /эх/-ийн нэр | Өөрийн нэр | Регистрийн дугаар | Оршин суугаа хаяг | Хаяг, байршил, газар зүйн нэр | Зориулалт | Хэмжээ /м²/ | Газар зүйн солбицол |
| 1 | Дүгэрсүрэн | Эрдэнэочир | ЗЛ84052918 | 2-р баг | 2-р баг Эрээн толгойн хойд хонхор | Өвөлжөө | 700 | N-46°44'12.7"<br>E-108°11'13.3" |
| 2 | Хорхой | Үзмээ | ЗН57091902 | 2-р баг | 1-р баг Цагаан ухаагийн ар хоолой | Өвөлжөө | 700 | N-46°38'04.9"<br>E-108°29'31.6" |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/87 Баянтал сум

Захирамжийн зарим хэсгийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Баянтал сумын Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/103 дугаар захирамжийн 1 дүгээр хэсэгт дэх Хонхор хэмээх газрыг Их овоо овогтой Дүгэрсүрэнгийн Эрдэн-Очир нь өөрийн хүсэлтээр цуцлах хүсэлт гаргасан тул газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Дээрх газрын эзэмших гэрээг цуцлан, газрын улсын бүртгэлээс хасч ажиллахыг газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/103 дугаар захирамжийн 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

42122025 1

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 17 өдөр Дугаар А/188 Баянтал сум

## Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дугаар зүйлийн 30.1, 52 дугаар зүйлийн 52.7 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэр бүхий 1 иргэнд өвөлжөө, хаваржааны доорхи газрын зориулалтаар хавсралтад заасан газрын байршилд 15 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрх олгосугай.

2. Дээрх газар эзэмших эрх авсан иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын төлбөр тооцох, газрын улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

42122026З

Сумын Засаг даргын 2022 оны ..... дугаар сарын .... ны өдрийн дугаар захирамжийн хавсралт

## Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг шинээр эзэмшиж байгаа иргэдийн нэрсийн жагсаалт

| дд | Газар эзэмшигчийн | | | | Эзэмшсэн газрын | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эцэг /эх/-ийн нэр | Өөрийн нэр | Регистрийн дугаар | Оршин суугаа хаяг | Хаяг, байршил, газар зүйн нэр | Зориулалт | Хэмжээ /$м^2$/ | Газар зүйн солбицол |
| 1 | Мөнхөө | Өлзийбаяр | ЕЙ70031217 | 2-р баг | 2-р баг Бөөгийн овооны зүүн талд | Өвөлжөө | 700 | N-46°43'19.4"<br>E-108°09'22.8" |
| | | | | | 2-р баг 16-р зөрлөгийн зүүн талд | Хаваржаа | 700 | N-46°45'09.1"<br>E-108°02'13.0" |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/89 Баянтал сум

Иргэн Г.Азжаргалыг асран хамгаалч
тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, сумын хамтарсан багийн шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Борнууд овогтой Ганчимэгийн Азжаргалыг /цх08260211/ өөрийн төрсөн ах болох Ганчимэг овогтой Төгөлдөрт /цх97053017/ асран хамгаалах эрх өгч шилжүүлсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын 1 дүгээр багийн Засаг дарга (Э.Түмэн-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

42122026 6

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/90 Баянтал сум

**Ур чадварын нэмэгдэл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зйүлийн 46.1, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35/А/10/9 дүгээр тушаалын 1 дүгээр хавстралын 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.1, 10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны 9 сар, 4 дүгээр улирлын ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын ур чадварын нэмэгдлийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч, нарын ур чадварын нэмэгдлийг журмын дагуу бодож олгохыг сургуулийн нягтлан бодогч /Ц.Жаргалмаа/, Цэцэрлэгийн нягтлан бодогч /Х.Ариунгуа/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг засаг даргын орлогч /Э.Эрхэмбаатар/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

421220271

Сумын Засаг даргын 2022 оны ..10.. сарын ..18..
ны өдрийн А/10 захирамжийн ..1.... хавсралт

**БАЯНТАЛ СУМЫН ЕБС-ИЙН ЗАХИРАЛ, СӨБ-ЫН ЭРХЛЭГЧ НАРЫН 2022 ОНЫ 09, 10, 11, 12 ДУГААР САРЫН УР ЧАДВАРЫГ ДҮГНЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

2022.09.24 ЛҮН

| Шалгуур | | 1.Манлайлал, менежментийн ур чадвар \50 оноо \ | | | | 2.Мэргэжил арга зүйн хөгжил, дэмжлэг \ 50 оноо\ | | Авах оноо | Авсан оноо | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ҮЗҮҮЛЭЛТ | | 1.1.ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ, ЭРҮҮЛ ОРЧИНД СУРАЛЦАХ, БАГШ АЖИЛЧДЫН АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ, ҮР ДҮН | 1.2.УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ | 1.3.ХАМТ ОЛНЫ ТӨЛӨВШИЛ, БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, БАГШ, АЖИЛТНЫ НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ | 1.4.БАГШ СУРАЛЦАГЧДАД ЗӨВЛӨН ТУСАЛЖ, ТУРШЛАГА ТҮГЭЭСЭН БАЙДАЛ | 2.1.БАГШИЙН МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАЙДАЛ, ҮР ДҮН | 2.2.СУРАЛЦАГЧДЫН СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ НӨХӨХ, ОД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙДАЛ, ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН | | | |
| **Авах оноо** | | **15** | **10** | **10** | **15** | **25** | **25** | **100** | | |
| | | | | | **2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САР** | | | | | |
| 1 | Д.Цэрэнням | **15** | **10** | **10** | **15** | **25** | **25** | **100** | **100** | **25** |
| 2 | Б.Энхмэнд | **15** | **10** | **10** | **10** | **10** | **25** | **100** | **80** | **20** |
| | | | | | **2022 ОНЫ 10 ДУГААР САР** | | | | | |
| 1 | Д.Цэрэнням | **15** | **10** | **10** | **15** | **25** | **25** | **100** | **100** | **25** |
| 2 | Б.Энхмэнд | **15** | **10** | **10** | **10** | **10** | **25** | **100** | **80** | **20** |
| | | | | | **2022 ОНЫ 11 ДУГААР САР** | | | | | |
| 1 | Д.Цэрэнням | **15** | **10** | **10** | **15** | **25** | **25** | **100** | **100** | **25** |
| 2 | Б.Энхмэнд | **15** | **10** | **10** | **10** | **10** | **25** | **100** | **80** | **20** |
| | | | | | **2022 ОНЫ 12 ДУГААР САР** | | | | | |
| 1 | Д.Цэрэнням | **15** | **10** | **10** | **15** | **25** | **25** | **100** | **100** | **25** |
| 2 | Б.Энхмэнд | **15** | **10** | **10** | **10** | **10** | **25** | **100** | **80** | **20** |

Үнэлгээний багийн ахлагч: Л.Отгонпүрэв
Үнэлгээний багийн гишүүн: Д.Өсөхбаяр
Үнэлгээний багийн гишүүн: Э.Буянтогтох

Үнэлгээг хянаж, баталгаажуулсан:
Баянтал сумын Засаг дарга: Г.Анхбаяр

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 20 өдөр Дугаар А/91 Баянтал сум

Газар эзэмших эрхийг дуусгавар болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 46.1, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6, 40.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу 2 жил дараалан газраа ашиглаагүй, сумын нутаг дэвсгэрийн хилийн гадна олгогдсон хавсралтад заасан иргэдийн газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.
2. Газар эзэмших эрх дуусгавар болгосныг иргэдэд мэдэгдэж, газрыг чөлөөлүүлэн хүлээж авахыг Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

21220270

Сумын Засаг даргын 2022 оны
10 сарын 20-ны өдрийн А/91 дугаар
захирамжийн хавсралт

## Газар эзэмших эрхийг дуусгавар болгосон иргэдийн жагсаалт

| дд | Овог нэр | Регистрийн дугаар | Газрын хэмжээ /$м^2$/ | Газрын байршил | Газрын зориулалт | Захирамжийн дугаар | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | М.Өлзийбаяр | ЕЙ70031217 | 700 | 2-р баг Их оорцогын өл | Өвөлжөө | 2009.09.04 А/89 | Сумын нутаг дэвсгэрийн хилийн гадна олгогдсон. |
| 2 | М.Өлзийбаяр | ЕЙ70031217 | 700 | 2-р баг Их оорцогын толгой | Хаваржаа | 2009.09.04 А/89 | Сумын нутаг дэвсгэрийн хилийн гадна олгогдсон. |
| 3 | Н.Эрдэнэбаатар | ЕЙ54031317 | 700 | 2-р Давайн хормой | Өвөлжөө | 2006.03.06 24 | Өөрийн хүсэлтээр цуцлах |
| 4 | Н.Эрдэнэбаатар | ЕЙ54031317 | 700 | 2-р Хөндлөн замын хонхор | Хаваржаа | 2006.03.06 24 | Өөрийн хүсэлтээр цуцлах |
| 5 | Р.Бадамсүрэн | ЗН70111405 | 700 | 2-р Замын толгойн баруун | Өвөлжөө | 2014.04.07 А/33 | Сумын нутаг дэвсгэрийн хилийн гадна олгогдсон. |
| 6 | Н.Суурь | ЕЙ39052001 | 700 | 2-р Их оорцог толгойн бууц | Өвөлжөө | 2012.11.28 А/113 | Сумын нутаг дэвсгэрийн хилийн гадна олгогдсон |
| 7 | Д.Батболд | ЗЖ82050531 | 700 | 2-р баг Хөх өндөрийн баруун | Хаваржаа | 2014.05.27 А/55 | Сумын нутаг дэвсгэрийн хилийн гадна олгогдсон. |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 20 өдөр Дугаар А/92 Баянтал сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 46.1, дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй батлалсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Э.Эрхэмбаатар - Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн дарга: | Ц.Загарсүрэн - Газрын даамал |
| Гишүүд: | М.Номинзул –ГХБХБГ-ын мэргэжилтэн |
| | Э.Түмэн-Эрдэнэ – 1-р багийн Засаг дарга |
| | Э.Ган-Эрдэнэ – 2-р багийн Засаг дарга |
| | Л.Батнасан -2-р багийн малчин |
| | Г.Баярмагнай - 1-р багийн малчин |

2.Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх ажлыг үр дүнтэй зохион байгуулан ажиллаж сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Эрхэмбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 20 өдөр Дугаар А/93 Баянтал сум

## Газар эзэмших эрхийг дуусгавар болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 40.2, тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч нь 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт Лүн уулын баруун талд байршилтай мал эмнэлгийн зориулалтай 2га/20000м.кв/ Газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу 2 жил дараалан газраа ашиглаагүй Церкон геологи ХХК (5961149) газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.
2. Газар эзэмших эрх дуусгавар болгосныг мэдэгдэж, газрыг чөлөөлүүлэн хүлээж авахыг Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/04 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.
4. Газар эзэмшигч нь Захиргааны ерөнхий хуульд заасан хугацаа, нөхцөл журмын дагуу дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

421220274

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 20 өдөр Дугаар А/94 Баянтал сум

Эд хөрөнгийг бүртгэлжүүлж, хариуцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2022 оны 3 дугаар улирлын байдлаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний 5 нэрийн 46,349,000 (Дөчин зургаа сая гурван зуун дөчин есөн мянган) төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгүүдийг хавсралтад зааснаар байгууллагынхаа эд хөрөнгийн бүртгэлд авахыг Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа)-д даалгасугай.

2. Эд хөрөнгийг 2022 оны жилийн эцсийн тайланд тусгаж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад холбогдох хууль, дүрэм журмын дагуу хяналт тавьж ажиллахыг байгууллагын даргад болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022ajil/zahiramj.doc

2122028б

Засаг даргын 2022 оны .... сарын..... өдрийн
...... дугаар захирамжийн хавсралт

## Бүртгэлд тусгах хөрөнгийн жагсаалт

| № | Төсөл хөтөлбөр арга, хэмжээ | Бүртгэл хүүлэх эд хөрөнгө | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт мөнгөн дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гамгшийн зардал | Цөлийн шар гутал | 1 | 364,000 | 790,000 |
| | | Цэрэг подволк | 1 | 44,000 | |
| | | Тактик цамц | 1 | 84,000 | |
| | | Цэрэг малгай | 1 | 44,000 | |
| | | Өмд, гител | 1 | 254,000 | |
| 2 | Бэлчээрийн хортон мэргэчидтэй механик, биологийн аргаар тэмцэх | Утагч | 4 | 2,196,000 | 5,446,000 |
| | | Нух ухагч | 5 | 3,250,000 | |
| 3 | Мал эмнэлгийн бог бодын хашаа | Төмөр хашаа | 1 | 4,500,000 | 4,500,000 |
| 4 | Иргэдэд үйлчлэх төвийн тоног төхөөрөмж | Хаалт-9м ухаалаг дэлгэц-1 ширээ-6, сандал-12 хүлээлгийн буйдан-2, буйдан-1, чанга яригч-1 | 1 ком | 33,963,000 | 33,963,000 |
| 5 | Худагт уст цэгийн засварлах | Худгийн QJD2-87m | 1 | 1,650,000 | 1,650,000 |
| | | Цахилгааны утас | 50м | | |
| | | Ус өргөх хоолой | 45м | | |
| | | Тросс | 100м | | |
| | | Цооногийн тагны иж бүрдэл, монтаж | 1 ком | | |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 24 өдөр Дугаар А/95 Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжүүлэх журам"-ын 4.13 дэх хэсгиийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн "Мал эмнэглийн бог бодын хашаа авах" барааг худалдан авах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Ган-Эрдэнэ (2-р багийн Засаг дарга)

Гишүүд:
Б.Төгөлдөр (ЗДТГ-ын байгаль хамгаалагч)
Н.Сарантуяа (ЗДТГ-ын аж ахуйн нярав)
Ц.Болдбаатар (ЗДТГ-ын жолооч)
М.Бодьгэрэл (Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

2. уг ажлыг ажлын даалгаврын дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавин хүлээж авахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. ажил хүлээлцсэн акт, гэрээ зэрэг бусад холбогдох бичиг баримтыг үндэслэн санхүүжилтийг олгохыг санхүү албаны ерөнхий нягтлан бодогч /Б.Энхтунгалаг/-д зөвшөөрсүгэй

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My document/2022ajil/zahiramj.doc

42122027

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
# БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 24 өдөр Дугаар А/96 Баянтал сум

Хөндлөнгийн хяналтын иргэдийн бүлэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны 86 дугаар журам”-ын 9.4, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бараа, ажил, үйлчилгээ хийгдсэн ажилд хөндлөнгийн хяналт хийх иргэдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Бүлгийн ахлагч: Г.Энхтунгалаг (иргэн)

Гишүүд:

С.Оюунчимэг (иргэн)
П.Цэцэгмаа (иргэн)
Ж.Цэвээндулам (иргэн)
П.Ганбаатар (иргэн)
Л.Батнасан (иргэн)
Г.Нансалмаа (иргэн)
О.Бадамцэцэг (иргэн)
С.Доржсүрэн (иргэн)
Ц.Жаргалмаа (иргэн)
Л.Энхтуяа (иргэн)
Л. Цэрэнханд (иргэн)
Ч.Отгонцэцэг (иргэн)
Ё.Эрдэнэчимэг (иргэн)
А.Энхбаяр (иргэн)
Б.Цэвэлмаа (иргэн)
Д.Цэдэвсүрэн (иргэн)
Э.Баасангарав (иргэн)



2122028 4

Засаг даргын 2022 оны .... сарын..... өдрийн

...... дугаар захирамжийн хавсралт

Хөндлөнгийн хяналт хийх ажлуудын жагсаалт

| № | Арга хэмжээ | Хөдлөнгийн хяналт хийх иргэн |
|---|---|---|
| 1 | Баяр наадмын талбайг засварлах, шинэчлэх | С.Оюунчимэг |
| 2 | 154-р байрны 3, 4, 5-р орцны урд талд 24*15 хэмжээтэй, 154, 125-р байрнуудын хажуу талд 2 хэсэг автомашины зогсоол хийх | П.Цэцэгмаа |
| 3 | Зураг төсөв | Ж.Цэвээндулам |
| 4 | Ногоон байгууламжийн усалгааны систем | П.Ганбаатар |
| 5 | 154, 152 дугаар байрнуудын хаалга шинэчлэх хаалганы хажуу талд салхи борооны хаалт, үүдний гэрэлтүүлэг | Л.Батнасан |
| 6 | Nргэдэд үйлчлэх төвийн тоног төхөөрөмж авах | Г.Нансалмаа |
| 7 | Явуулын соёлын үйлчилгээний тоног төхөөрөмж | О.Бадамцэцэг |
| 8 | Худаг уст цэгийг сэргээх, засварлах хамгаалах | С.Доржсүрэн |
| 9 | Мал эмнэлгийн бог бодын хашаа барих | Ц.Жаргалмаа |
| 10 | Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх | Л.Энхтуяа |
| 11 | Сумын баяр наадмын зардал | Л. Цэрэнханд |
| 12 | Сэг зэм устгах цэгүүдийг тэмдэгжүүлэх, халдваргүйжилтийг сайн хийх | Ч.Отгонцэцэг |
| 13 | Бэлчээрийн хортон мэрэгчидтэй механик, биологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулах | Ё.Эрдэнэчимэг |
| 14 | Бэлчээрийн олон наст ургамал тариалах ажлыг зохион байгуулах | А.Энхбаяр |
| 15 | Отор нүүдлээс бэлчээр хамгаалах, чөлөөлөх ажлыг зохион байгуулах | Б.Цэвэлмаа |
| 16 | Газарзүйн байршлын цэг тэмдэглэгээ тогтоох ажлыг зохион байгуулах | Д.Цэдэвсүрэн |
| 17 | Тохижилт, гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээний зардал | Э.Баасангарав |
| 18 | Тэжээлийн нөөц бүрдүүлэх | Б.Энхтөр |
| 19 | Малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардал | Д.Зоригт |
| 20 | Малын чанарыг сайжруулах | Г.Энхтунгалаг |

Б.Энхтөр (иргэн)

Д.Зоригт (иргэн)

2. 2022 онд ОНХС-гийн үйл ажиллагаанд Хөндлөнгийн хяналт хийх ажлуудыг хавсралтаар баталсугай.

3. Хөндлөнгийн хяналтын иргэдийн бүлэг нь хяналт хийхдээ хууль журмын дагуу хийж, үр дүнг тухай бүрд нь танилцуулахыг үүрэг болгосугай

ДАРГА Г.АНХБАЯР

ОНХС-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

/Иргэн, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

2022 оны ....-р сарын .....өдөр Баянтал сум

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 2022 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй "______________________________" худалдан авах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ /доогуур зур/-ний хэрэгжилтийн үр дүнд иргэн, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл /доогуур зурах/ ............................................................ би бээр 2022 оны.....сарын ....өдөр хяналт тавьж ажиллав.

1. Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зорилго:

..........................................................................................................................................................

2. Хүрсэн үр дүн:

..........................................................................................................................................................

..........................................................................................................................................................

3. Хөрөнгийн өмчлөл, ашиглалт:

..........................................................................................................................................................

4. Ашиг хүртэгсэд /ашиглагч байгууллага/:

..........................................................................................................................................................

5. Ашиг хүртэгсдийн сэтгэл ханамжийн байдал:

..........................................................................................................................................................

6. Дүгнэлт:

..........................................................................................................................................................

..........................................................................................................................................................

7. Зөвлөмж:

..........................................................................................................................................................

..........................................................................................................................................................

8. Ерөнхий үнэлгээ:

..........................................................................................................................................................

..........................................................................................................................................................

Хяналт, үнэлгээ хийсэн:

..................................................................................

/овог, нэр/ /гарын үсэг/

утасны дугаар: .......................................................

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 26 өдөр Дугаар А/97 Баянтал сум

**Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.5, 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022/07 дугаартай ус ашиглуулах тухай дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Генерго” ХХК-ны захирал Г.Туул, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол, 10-62 тоот нь сумын нутагт байрлах “Дэлгэрийн тал” нэрт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газарт Ашигт малтмалын эрэл хагйуулын өрөмдлөгийн ажилд ажилчдын унд ахуйн хэрэгцээний усыг сумын төв худгаас зөөврөөр авч ашиглах хүсэлт гаргасны дагуу ус ашиглах зөвшөөрөл олгосугай.

2.“Генерго” ХХК-тай гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавин ажиллахыг байгаль хамгаалагч (Б.Төгөлдөр)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга /Э.Эрхэмбаатар/-д даалгасугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

4212220283

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 26 өдөр Дугаар А/98 Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа,нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1,Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2022 оны "Явуулын соёлын үйлчилгээний тоног төхөөрөмж нийлүүлэгч"-ийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Э.Эрхэмбаатар ( Засаг даргын Орлогч дарга )

Гишүүн: О.Гантөмөр (Соёлын төвийн аж ахуйн нярав)

Нарийн бичгийн дарга: М.Бодьгэрэл (Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу явуулахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн зөвлөмжид үндэслэн шалгарсан нийлүүллэгчтэй гэрээ байгуулах гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа)-д үүрэг болгосугай.

4. Хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг тухайн байгууллагын бүртгэл, тайланд тусгуулж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг нийгмийн бодлого, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн (М.Бодьгэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

4212220310

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН

ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 28 өдөр Дугаар А/99 Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа,нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1,Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2022 оны "Ногоон байгууламжийн усалгааны систем нийлүүлэгч"-ийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Э.Эрхэмбаатар ( Засаг даргын Орлогч дарга )

Гишүүн: Б.Төгөлдөр (Байгаль хамгаалагч)

Нарийн бичгийн дарга: М.Бодьгэрэл (Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу явуулахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн зөвлөмжид үндэслэн шалгарсан нийлүүллэгчтэй гэрээ байгуулах гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа)-д үүрэг болгосугай.

4. Хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг тухайн байгууллагын бүртгэл, тайланд тусгуулж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг нийгмийн бодлого, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн (М.Бодьгэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

42122031

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 28 өдөр Дугаар А/100 Баянтал сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа,нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1,Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Орон нутгийн өвсний нөөц бүрдүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 210 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2022 оны "Тэжээлийн нөөц бүрдүүлэх нийлүүлэгч"-ийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Ган-Эрдэнэ (2-р багийн Засаг дарга)

Гишүүн: Т.Эрдэнэбаяр (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Бодьгэрэл (Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу явуулахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн зөвлөмжид үндэслэн шалгарсан нийлүүллэгчтэй гэрээ байгуулах гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа)-д үүрэг болгосугай.

4. Хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг тухайн байгууллагын бүртгэл, тайланд тусгуулж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг нийгмийн бодлого, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн (М.Бодьгэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

421220312

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 28 өдөр | Дугаар А/101 | Баянтал сум

**Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалтууд, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа явуулах тухай Сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/83 дугаар захирамжын дагуу 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр болох газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг танхимын хэлбэрээр зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | М.Бодьгэрэл-( Хууль эрх зүй Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн) |
| Нарийн бичгийн дарга: | Ц. Загарсүрэн – (Газрын даамал) |
| Гишүүд: | Л.Отгонпүрэв – Санхүү албаны дарга) |

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг журмын дагуу чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (М.Бодьгэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

42122032 1

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 28 өдөр     Дугаар А/102     Баянтал сум

## Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.1.7, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, туузрын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журмын 5.1.4, 5.1.7 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/205 тоот “Отор, нүүдлийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, хяналт тавих тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Баянтал сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр дэх “Хоёр цагаан худаг” гэдэг газарт 2022 оны 10 дүгээр сарын 22-ны өдөр Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 2 дугаар багийн малчин С.Нармандахаас 2 бух мал эмнэлгийн гэрчилгээгүй, мал, амьтны эрүүл мэндийн бүртгэлийн дэвтэргүй ирсэн тул 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоосугай

2.Тус нутаг дэвсгэрт хязгаарлалт тогтоож, малын шилжилт хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн гаргах, оруулах зэргийг хориглож ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Д.Чанцалдулам), 2 дугаар багийн Засаг дарга (Т.Ган-Эрдэнэ) нарт даалгасугай.

3.Хязгаарлалт тогтоосон нутаг дэвсгэр дэх малд үзлэг хийх, хашаа хорооны ариутгал халдваргүйтгэл хийхийг “Хилийн дэлгэрэх” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (Л.Сүрэнсүгир)-д даалгасугай.

4.Хязгаарлалтын дэглэм тогтоосон газар, бэлчээрийн ойролцоо байгаа малчин, мал бүхий иргэд хязгаарлалтын дэглэмийг мөрдөх, захирамжийн биелэлтэнд хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА          Г.АНХБАЯР

D;/My Documents/2022 ajil/zahiramj.doc

421220316